

(ЭША. Ч.Эрдэнэбаяр) зэрэг эрдэм шинжилгээний сонирхолтой илтгэл хэлэлцэж, сонирхсон сэдвээр эрдэмтэд санал, онолоо солилцов.

Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өнгөрсөн хугацаанд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудаас бичиж нийтэлж байсан бүтээлийн жагсаалтыг «Хэвлэгдсэн бүтээлийн хэлхээс» (1968—1993 он) нэртэйгээр жижиг товхимол болгон хэвлэн гаргалаа.

Мөн «Арга билэг» сонины нэг дугаарыг хүрээлэнгийн ойд зориулан гаргаж, хүрээлэнгийн түүх, ажил үйлс, тус хүрээлэнгийн ахмад ажилтнуудын дурсамж, хүрээлэнгийн бүтээлийн дээж, судалгаа шинжилгээний ажлын чиглэл, зорилтуудаас гадна хүрээлэнгээс эрхлэн гаргадаг олон улс судлалын анхны «Дорно-Өрнө» сэтгүүлийн 15 жилийн ой давхцаж байгаатай холбогдсон дурсамж өгүүллийг нийтэлжээ.

## МАНАЙ ЛАВЛАХ

## 1993 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ (эхний хагас жилд)

1993.01.07 Монгол улс, Бүгд найрамдах Словак Улсын хооронд дипломат харилцаа тогтоов.

1993.01.09 Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар ажлын түр айлчлал хийхээр Улаанбаатарт хүрэлцэн ирсэн Буриад Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга В. Б. Саганов хоёр орны эдийн засаг, худалдаа боловсрол, шинжлэх ухаан, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоёр талын хилийн боомт болох Хиагт, Алтанбулагийн асуудлаар Ерөнхий сайд П.Жасрайтай санал солилцов.

1993.01.12. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Улсын Их Хурлын төлөөлөгчид БНФУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж Францын албаны хүмүүстэй уулзаж, хоёр орны харилцааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон байна.

Мөн ХБНГУ-д албан ёсны айлчлал хийж ХБНГУ-ын Бранденбург муж улсаар зочилж тус муж улсын ган цувималын үйлдвэртэй танилцаж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд шилжих явцад учирч буй хүндрэл бэрхшээл, өмч хувьчлалын явцын талаар санал солилцсон байна.

Мөн Европарламентэд зочлон ерөнхийлөгч Е. Кленш, Европарламентын гадаад асуудал, аюулгүй байдлын байнгын хорооны дарга болон зарим гишүүдтэй уулзаж бүгд хуралдаанд нь орж сонирхсон байна.

1993.01.14, 15 Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Парис хотноо болсон «Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх, түүнийг устгах тухай» конвенцид гарын үсэг зурж мөн Итали улсад зочлон тус улсын Гадаад хэргийн сайд Эмилио Коломботой уулзаж хоёр талын харилцааны асуудлаар санал солилцож,

тэд хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих харилцан хамгаалах тухай» Монголын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав.

1993.01.19—23 Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбат Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч Борис Ельциний урилгаар ОХУ-д албан ёсны найрсаг айлчлал хийв. П. Очирбат, Б. Ельцин нар хэлэлцээ хийж Монгол улс, Оросын Холбооны улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээнд гарын үсэг зурлаа.

Хэлэлцээний үеэр хоёр Ерөнхийлөгч олон зуун жилийн найрсаг харилцаат хөрш хоёр орон сайн сайхан уламжлалаа хадгалан, дэлхий нийтийн нийтлэг дэг ёсны дагуу цоо шинэ маягаар харилцан ашигтай хамтран ажиллах эрх зүйн үндсийг тавина гэдгээ илэрхийлж өнгөрсөн жилүүдэд ЗХУ-аас үзүүлсэн эдийн засаг, санхүү, техникийн тусламжийн хүрээнд үүссэн өрийн асуудлыг хөндөж, Монголоос төлөх өрийн тухай асуудлыг ажлын хэсгийн дүгнэлтийг гартал хойшлуулахаар тохирч, хуучин БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулагдсан гэрээ хэлэлцээрүүдийг дахин хянан таарах зүйлийг хэвээр үлдээж үл зохицохыг хүчингүй болгож шинэчлэх, үүнд соёл, эрүүлийг хамгаалах, мэдээлэл солилцох зэрэг салбарын гэрээ хэлэлцээрүүдийг оруулах, мөн Монголд байгаа орос иргэд ОХУ-д монгол иргэдийн эрхийг хамгаалах хууль зүйн актуудыг бэлтгэх нь зүйтэй гэж үзсэн байна. Мөн 1930—1940-өөд оны үеийн хэлмэгдүүллийн асуудлаар Ерөнхийлөгч нар санал бодлоо солилцож хамтарсан мэдэгдэл гаргалаа.

П.Очирбат, Б. Ельцин нар хоёр талын болон бүс нутаг, дэлхий дахины анхаарал татсан бусад асуудлыг хөндөж санал солилцов.

П.Очирбат Монгол улсын гадаад бодлогын талаар хойд, урд хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцах, эдийн засгийн нээлттэй бодлогыг онцлон эрхэмлэхээ дурьдав. 1993.01.27. Монгол улс, БНАСАУ-ын Засгийн газрын хуралдааны төлөөлөгчдийн хэлэлцээ Пхеньян хотноо болж 1992 оны худалдааны үйл ажиллагааг дүгнэж, 1993 онд харилцан бараа солилцох болон хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах жижиг, дунд хэмжээний хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зэрэг санал солилцон протокол байгуулав.

1993.01.29. Азийн хөгжлийн банк монголын дүн бүртгэлийн системийг сайжруулах, хөдөө аж ахуйн шинэ төсөл бэлтгэхэд зориулж 900 мянган ам. долларын техникийн зээл олгох баталгаа өгсөн байна. Эхний 500 мянган долларын зээлийг үйлдвэр, худалдааны албадад, шинжлэх ухааны үндэстэй зохион

бүтээх систем бий болгох, улсын хэмжээний дүн бүртгэл статистикийн бусад тоо баримт хадгалах, үндэсний цахим тооцоолуурын төвийн боломжийг нэмэгдүүлэхэд ашиглах юм байна.

400 мянган долларын хэмжээтэй хоёр дахь зээлийг Хөдөө аж ахуйд шинэчлэл, хадгалалт хувиарлалтын төсөл бэлтгэхэд зориулах юм байна.

1993.02.02 1993 оны нэгдүгээр сарын нэгний байдлаар Монголоос гадаадад ажиллахаар гарсан хүний тоо 41086 болов. Үүнээс Казахстанд 39140 (хөдөлмөрийн насных нь 17182), ОХУ-д 1266 хүн ажиллахаар явжээ.

1993.02.02 Японы парламентын төлөөлөгчдийн танхимын дарга Е. Сакураучи, Японы ерөнхий сайдын орлогч, ГЯЯ ны сайд М. Ватанабе нар Монголын Худалдаа үйлдвэрийн сайд Ц.Цогтыг Токио хотноо тус тус хүлээн авч уулзан хоёр орны харилцааны талаар санал солилцсон байна.

1993.02.05 Монгол Улсын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО-ын Монголын үндэсний комиссын дүрэм, комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлав.

1993.02.10 Япон улсаас Монгол улсад 20 сая доллартай тэнцэх нэн яаралтай импортын бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх зээл тусламжийн тухай Засгийн газар хоорондын нотод Худалдаа, үйлдвэрийн сайд Ц. Цогт манай улсад Япон улсын хэргийг түр хамаарагч Фумиаки Томинага нар Улаанбаатар хотноо гарын үсэг зурлаа.

Өнгөрсөн оны 5-р сард Токиод болсон хандивлагч орнуудын зөвлөлгөөнөөр Монгол улсын эдийн засгийн цаашдын хөгжлийн суурийг тавих төсөлд зориулан 50 сая орчим ам. долларын зээлийг Японы Засгийн газар олгох болсоны нэг хэсэг нь энэхүү 20 сая доллар юм байна.

1993.02.17 Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай олон улсын валютын сангийн хэлтсийн дарга М. Фетерстон тэргүүтэй ажлын хэсгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Ноён М. Фетерстон өнгөрсөн оны аравдугаар сард Монгол улсын Засгийн газар, олон улсын валютын сантай тохиролцсон бодлогын чанартай арга хэмжээний хэрэгжилт, 12-р сарын эцэст хангасан байх ёстой эдийн засгийн үзүүлэлтүүдийн талаарх ажлын хэсгийн дүгнэлтийг танилцуулав.

Уулзалтын үеэр Ерөнхий сайд П.Жасрай, ноён М. Фетерстон нар бодлогын шинжтэй зарим арга хэмжээний талаар санал солилцож, цаашид Монгол улс, Олон улсын валютын сангийн хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

1993.02.19 Бүгд Найрамдах Казахстан улсын Ерөнхийлөгч Н. А. Назарбаев Монгол улсаас БНКаЗУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Э.Бямбажавыг хүлээн авч уулзан хоёр орны харилцааны талаар санал солилцов.

1993.02.18 Монгол улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар Монгол улс, Бүгд Найрамдах Словени улсын хооронд элчин сайдын яамны хэмжээнд дипломат харилцаа тогтоов.

1993.02.19 Монгол улсын ерөнхий сайд П.Жасрай Английн «Би Би-Си»-гийн телевизийн сурвалжлагч ноён Брайэн Барроныг төрийн ордонд хүлээн авч уулзан ярилцлага өглөө. Ерөнхий сайд П.Жасрай сурвалжлагчийн асуултад хариулахдаа, манай орны хувьд ардчилал хөгжиж төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн чөлөөт тогтолцоонд шилжих явцад түлш-эрчим хүчний хямрал, шингэн түлш, шатах тослох, материалын болон хүнсний бүтээгдэхүүний хомсдол зэрэг тулгамдсан гурван үндсэн асуудал, байна гээд гадаадын олон орон, байгууллагуудаас их туслалцаа үзүүлж байгаад баярлаж байгаагаа дурьдаад манай орны хувьд зах зээлээ зөв олж, аль бололцоотой харилцан ашигтай байх чиглэлийг эрхэмлэнэ гэлээ.

1993.02.27 Монгол улс, Бүгд Найрамдах Босна-Герцеговина улсын хооронд дипломат харилцаа тогтов.

1993.02.27 Монгол улсын Их Хурлын дарга Н.Багабанди Монгол улсын Дээд шүүхийн урилгаар ирсэн Оросын Холбооны улсын Дээд шүүхийн дарга В. М. Лебедев тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Тэд хоёр орны хооронд шүүхийн салбарт хамтран ажиллах, Орос улсад мэргэжил эзэмшсэн хуульчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, энэ салбарт мэргэжилтэн, мэдээлэл солилцох бололцоо байгааг тэмдэглэв.

1993.03.10 Монгол улс, Бүгд Найрамдах Хорват улсын хооронд дипломат харилцаа тогтов.

1993.03.12 Монгол улсын Ерөнхий сайдын орлогч Ч., Пүрэвдорж Монгол, Оросын Засгийн газар хоорондын монголын хэсгийн хурлыг хийлгэж Монгол улс, ОХУ-ын хооронд 1993 онд бараа харилцан нийлүүлэх эрх олж авахын төлөө тендер зарлаж дүгнэх шийдвэр гарган Засгийн газар хооронд байгуулах гэрээ хэлэлцээрүүдийн төслийг бэлтгэх ажлын хэсэг байгуулав. ОХУ-д төлөх зээлийн өрийн 1991—95 онд ногдох хэсгийг хүүгийн хамт 2000 оноос цааших хугацаанд хойшлуулах тухай Засгийн газар хооронд 1992 оны 9-р сард үсэглэсэн «Солилцох захидалд» гарын үсэг зурахыг ХҮЯ-ны сайдад даалгаж Мардайг түшиглэн холимог металлын ордыг ОХУ-тай хамтран ашиглах асуудлыг Геологи, эрдсийн баялгийн яаманд үүрэг болгов.

1993.03.12. Монгол улсын Сангийн сайд Д.Даваасамбуу Монголын хөгжлийн бодлогыг дэмжих Японы хэсгийн Р. Хироно ахлагчтай төлөөлөгчдийг хүлээн авч уулзан санал солилцов. Японы профессор, манай Засгийн газрын гишүүн хоёр Монголын эдийн засгийг эрүүлжүүлэх эмчилгээг түргэтгэхээс аргагүй боллоо гэдгийг хүлээн зөвшөөрлөө.

1993.03.20 Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай Японы Сейкейн их сургуулийн профессор Р. Хироно тэргүүтэй төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

1993.04.02 Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц, Гомбосүрэн Бүгд Найрамдах Казахстан улсад албан ёсны айлчлал хийж БНКаз Улсын Гадаад явдлын яамны сайд Т. С. Сулейменовтай уулзаж хэлэлцээ хийлээ. Сайд нар хоёр орны хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой асуудлаар санал солилцож, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны засгийн газар хоорондын комисс байгуулах, түүний хийж гүйцэтгэх ажлын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

Ц.Гомбосүрэн сайд Бүгд Найрамдах Кыргызстан улсад албан ёсны айлчлал хийж Кыргызстаны Ерөнхийлөгч А. А. Акаевт бараалхан Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбатын илгээмж-урилгыг түүнд гардуулсан байна.

Тэрээр БНКыр. Улсын Гадаад явдлын яамны сайд Э. Карабаевтай хэлэлцээ хийж Монгол, Кыргызстаны найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны гэрээг үзэглэж, хоёр орны Засгийн газар хооронд соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр, Кыргызстаны гадаад явдлын яам, Монголын Гадаад харилцааны яамны хоорондын хамтын ажиллагааны тухай протоколд тус тус гарын үсэг зурсан байна.

1993.04.13 БНЭУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт 50 сая рупийн (1 сая 760 мянган долларын) хөнгөлөлттэй зээл олгох тухай хэлэлцээрт тус улсаас БНЭУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Чулуундорж, Энэтхэг улсын Сангийн яамны хэлтсийн дарга Д. Субарро нар энэ 4-р сарын 8-нд гарын үсэг зурав. Уг зээлийн хөрөнгөөр хүнсний тос, цемент, ардын уламжлалт эмнэлгийн эмийн хэд хэдэн жижиг үйлдвэр Монголд барьж байгуулах ажээ.

1993.04.16 Германы Берлин хотноо Монголын улс төр, соёлын өдрүүд болж өргөн цар хүрээтэй өвөрмөц онцлог арга хэмжээнүүдийг зохион явууллаа. Монголын үйлдвэр, худалдааны томоохон компани, байгууллагын төлөөлөгчид Германы ижил төрлийн байгууллагуудтай ажил хэргийн маш үр дүнтэй уулзалт, зарим пүүс, компаниуд гэрээ хэлцэл хийсэн

байна. Мөн Германд амьдардаг монгол иргэд болон оюутнуудын уулзалт, урлаг спортын тоглолт болж, цамын бүжгийн хэрэгслээр үзэсгэлэн гаргав. Энэ арга хэмжээнд Германы талаас 21 байгууллагын төлөөлөгч оролцсон байна.

1993.04.23 Оросын Холбооны Бүгд Найрамдах Саха (Якут) улсын Ерөнхийлөгч М. Ч. Николаев, Монгол улсад айлчилж Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбатад бараалхан, Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрайтай уулзаж, хэлэлцээ хийлээ. Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нар хоёр орны эдийн засгийн бодит байдал, зах зээлд шилжих явцын ололт амжилтаас харилцан танилцуулж, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, соёл, спорт, хэвлэл мэдээллийн салбарт, хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндэс гэрээ хэлэлцээр байгуулах, үнэт металлыг олборлон боловсруулах зэрэг асуудлаар санал солилцож Монгол улс, ОХ-ны Бүгд Найрамдах Саха улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

1993.04.30 Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди Америк Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал, ноён Д. Теллеспии тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

1993.05.01 Монгол улсын Ерөнхий сайдын орлогч Ч, Пүрэвдорж АНУ-д ажлын айлчлал хийв. Тэрээр АНУ орох замдаа Бээжин, Токиод саатаж БНХАУ-ын Гадаад явдлын яамны орлогч сайдтай уулзаж, Токиод, тэнд суугаа өөрийнхөө элчин сайд, түүний зөвлөхтэй уулзан хандивлагч орнуудын Токиогийн зөвлөлгөөний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар үүрэг даалгавар өгсөн байна.

Вашингтонд АНУ-ын Засгийн газар болон НҮБ, ОУВС, Дэлхийн банкны зарим удирдах хүнтэй уулзаж Монголын Засгийн газрын байр суурь ОУВС-тай хамтарч боловсруулсан ЕСАФ буюу дунд хугацааны хөтөлбөрийн талаар санал солилцсон байна. Мөн АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч (Ази, Номхон далайн орнуудын асуудал эрхэлсэн) Уэнстон Лордтой уулзан АНУ-ын шинэ Засгийн газарт улс орныхоо өнөөгийн байдал, Засгийн газрынхаа бодлого, үйл ажиллагааг тайлбарлаж энэ оны хоёрдугаар хагаст болох Монгол улсын ерөнхий сайдын ажлын айлчлалын бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар ярилцав.

1993.05.07 Саяхан Японы Такашима аралд Монголчуудын амьдрал, ёс заншлыг монголчуудад таниулах зорилготой монгол маягийн хотхон нээх ёслол болж Монгол улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б.Должинцэрэн, тус арлынхантай шууд харилцаатай Өвөрхангай аймгийн Хужирт сумын засаг дарга Дамчаабадгар, засаг дарга байсан Г.Очир,

Такашима арлын засаг дарга М. Миямото болон японы парламентын гишүүд, муж, хотын дарга нар оролцжээ.

1993.05.12 Монгол улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд П. Үржинлхүндэв, БНСУ-ын ГЯЯ ны Гэрээ эрхийн газрын дарга Син Хё Хон нар Сеул хотноо Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос улсын хооронд 1992 онд байгуулсан «Давхар, татвар ногдуулахгүй байх татвараас зайлсхийхийг сэргийлэх тухай хэлэлцээрийн батламж жуух бичиг солилцох протоколд гарын үсэг зурав.

1993.05.14 Монгол улсын Ерөнхий сайд П. Жасрай, Японы эдийн засгийн төлөвлөлтийн газрын эдийн засгийн хүрээлэнгийн орлогч захирал «Митсуй» корпорацийн зөвлөх Юужи Курокаваг хүлээн авч уулзан Монгол орныг зах зээлийн харилцаанд шилжүүлэх асуудлаар санал солилцов. Ноён Юужи Курокава манай улсыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх болон аж үйлдвэрийн бодлогын асуудлаар зах, зээлийн хүрээлэнд мэргэжлийн зөвлөлгөө өгч судалгаа хийсэн байна.

1993.05.25 Улсын Их Хурлын дарга Н.Багабанди Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны ерөнхийлөгч ноён Вилларозел Ландерийг төрийн ёслолын өргөөнд хүлээн авч уулзав. Ноён Ландер олон улсын нийгэмлэгүүдийн холбооны 154 гишүүний нэг МУЗН-ийн үйл ажиллагааг өндөр үнэлж, цаашид энэ байгууллагыг улам дэмжиж, Монголын ард түмэнд үзүүлэх хүмүүнлэг тусламжаа өргөтгөхөд бэлэн байгаагаа илэрхийллээ. Мөн Монгол улсад хандивлагч орнуудын Улаан загалмайн байгууллагуудтай МУЗН-ийг нягт холбох шаардлагатайг тэмдэглээд энэ үйл хэрэгт туслалцаа үзүүлнэ гэв.

1993.05.26 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсаас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Антони Бернард Мори даваа гаригт төрийн ордонд УИХ-ын дэд дарга Ж. Гомбожавтай уулзаж хувиасаа парламентын номын санд бэлэглэж буй «Британика» нэвтэрхий толийн бүрэн ботийг гардуулав.

Энэхүү нэвтэрхий толь бичиг 225 жилийн өмнөөс гарч эхэлсэн бөгөөд одоогоор 29 боть хэвлэгдсэн дэлхий нийтийн чанартай томоохон толь бичгийн нэг юм.

1993.06.08 1993 оны 6-р сарын 6-ний өдрийн ням гаригт Монгол улсад төрийнхөө тэргүүнийг анх удаа бүх нийтээр сонгох Ерөнхийлөгчийн сонгууль амжилттай явагдаж дууслаа. Улсын хэмжээгээр 1105944 сонгогч нэрсийн жагсаалтад бичигдсэнээс 1025534 сонгогч буюу 92,7 хувь нь саналаа өгч сонгогчдын 38,7 хувь буюу 396870 сонгогч МАХН-аас нэрийг нь дэвшүүлсэн

Л.Түдэвийн төлөө, 57,8 хувь буюу 592622 сонгогч МҮАН, МСДН-ын эвслээс нэр нь дэвшигдсэн П.Очирбатын төлөө саналаа өгч сонгогчдын олонхийн санал авсан одоогийн Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбатыг Монголын ард түмэн Ерөнхийлөгчөөрөө дахин сонголоо.

1993.06.11 Монгол улсын Ерөнхий сайд П. Жасрай Засгийн газраас ойрын үед хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар лхагва гаригт гадаад, дотоодын сурвалжлагчид, хэвлэлийн ажилтнуудад мэдээлэл хийлээ.

Сонгуульд Ерөнхийлөгч П.Очирбат яллаа. Үүнтэй холбогдоод таны болон танай Засгийн газрын бодлого өөрчлөгдөх үү? гэсэн «Ройтер» агентлагийн сурвалжлагчийн асуултад ерөнхий сайд: «Ерөнхийлөгч П. Очирбат бид хоёр ард түмнээс хүлээлгэсэн өндөр итгэл найдвар бүхий хүнд ачааг сүүлийн жил шахам хугацаанд хамт үүрч яваа хүмүүс, цаашдаа ч хамтран зүтгэх болно. Засгийн газар, Ерөнхийлөгчийн харилцан ажиллах зарчмыг хуулиар тов тодорхой заасан. Иймд Ерөнхийлөгч, Засгийн газрын хамтын ажиллагаа, урьдын адил үр бүтээлтэй байна гэдэгт би итгэл төгс байна гэв.

1993.06.11 Монгол улсын болон Монгол-Хятадын харилцааны түүхийг гуйвуулахыг оролдсон «Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир» хэмээх ном Бээжин хотод хэвлэгдэн гарсантай холбогдуулан албан ёсны тайлбар өгөх асуудлыг Хятадын талд дипломат шугамаар тавьсны хариуд БНХАУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэй Зян «Бээжинд ийм ном хэвлэгдсэнийг Хятадын Засгийн газар анхааралдаа авч, шуурхай арга хэмжээ авч уг номыг битүүмжлэж, номыг дахин хэвлэх, худалдахыг хориглов.

Энэ ном нь зөвхөн зохиогчдын хувийн санаа бодол бөгөөд Хятадын засгийн газрын бодлогыг илэрхийлээгүй болно. Хятадын Засгийн газар Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэн ирсэн бөгөөд цаашид ч ийм бодлогыг тууштай баримтална» гэж БНХАУ-ын Засгийн газрын байр суурийг Монгол улсын Гадаад харилцааны яаманд мэдэгдлээ.

1993.06.12 Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбат Монгол улс, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕЭЗХН)-ийн хамтарсан хорооны анхдугаар хуралдаанд оролцсон ЕЭЗХН-ий комиссын гадаад эдийн засгийн харилцааны ерөнхий газрын орлогч захирал Ж. Жиола тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан харилцан санал солилцлоо.

Мөн Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай, ноён Ж. Жиола тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч хоёр

талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон байна.

1993.06.12 Монгол, Оросын бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор энэ 7-р сарын эцсээр Монгол, Оросын хилийн боомтод болох уулзалтыг зохион байгуулах ажлын протоколд Улсын Их Хурлын гишүүн, Монгол, Оросын парламент хоорондын бүлгийн дарга Ж. Болдбаатар Оросын Холбооны улсын Дээд Зөвлөлийн гишүүн «Орос, Монгол» парламент хоорондын холбооны дарга В. Б. Нимаев нар гарын үсэг зурлаа,

## RESUMES

### **B. Tumen**

#### WORLD AND APR ECONOMIC SITUATION: TRENDS AND INTEGRATION

This issue is carefully examined by the writer in the context of elaboration of Mongolia's national development conception. The article stresses that as humanity is nearing to step over the threshold of the 21 st century there arise questions such as what will be civilization's future in the new century, the main socio-economic development trends and relative models to be followed etc. These and other ideas and conceptions are dealt with in it. Basing his opinion on these conceptions the author analyses the world and APR economic, scientific, technological cooperation, opportunities it offers, general trends towards integration, and questions relating to Mongolia's position and participation in this process.

### **O. Oyungerel**

#### JAPAN VIS-A-VIS APR IN THE '90 S

The changes that have occurred elsewhere in the world are now coming close to the Asia-Pacific Region. In this context Japan's role, politically and economically, is increasing as ever before. Being a G-7 member Japan has extended aid programme to under developed countries through donations, credits and investments. In addition, proceeding from the position of prestige, power and influence, it has advanced a number of political and economic initiatives, projects. While expressing its attitudes on various questions including regional trade-economic integration and security, Japan has proposed to make interstate dialogues a tradition.

The author made an attempt to throw light on issues such as Japan's militarization, security in Asia and hotbeds of tension therein.

### **Ts. Batbayar**

#### TAIWAN AND SOUTH KOREA: DEVELOPMENTAL PARALLELS AND DIVERGENCIES

The author deals with the initial conditions favouring the economic successes achieved of Asia's four tigers-especially of Taiwan and South Korea, having in mind that the latters had been within Japan's development structure, and the role of U. S. military and economic aid.

Nevertheless, it should be noted that there existed internal factors enabling to choose a new long-term direction of development to stimula-